



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 1/47

Улаанбаатар хот

Зарим ажилтанд мэргэшлийн
зэргийн нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоол, Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам, Эрүүл мэндийн сайдын “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам батлах тухай” 2019 оны А/513 дугаар тушаал, 2022 оны “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох тухай” А/368 дугаар тушаал, ЦССҮТ-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 4.10.3, 4.21.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Мэргэшлийн Тэргүүлэх зэрэг хүртсэн Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч эмч М.Цэрэндэжид, Донор зохион байгуулалтын тасгийн Технологич сувилагч Ц.Батцэцэг, Үйлдвэрлэлийн тасгийн Технологич сувилагч П.Цэндхүү, Б.Дуламсүрэн нарт албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хувиар тооцож, Мэргэшлийн Ахлах зэрэг хүртсэн Нэгдсэн лабораторийн тасгийн Их эмч Н.Баяртогтоход албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувиар тооцож 2022 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр олгохыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

2. Мэргэшлийн зэрэг ахиулсан М.Цэрэндэжид, Ц.Батцэцэг, П.Цэндхүү, Б.Дуламсүрэн, шинээр хүртсэн Н.Баяртогтох, мэргэшлийн зэрэг шинэчлэн тогтоосон Н.Гантөмөр нарт баяр хүргэж, мэдлэг, ур чадвараа ахиулан, мэргэшлийн зэрэг шинээр авах, ахиулах чиглэлд идэвхтэй ажиллахыг нийт ажилтнуудад уриалсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР



D:\bichig hereg\ALBAN BICHIG\Tushaal\tushaal-2022\A.docx

1118266548 11.9123905

080231